

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 06-р сарын 29-ний өдөр


Дугаар 06/01

Улаанбаатар хот

Дарга томилох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дах хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2 дах хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани /цаашид "Компани" гэх/-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.30 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/-ийн 2020 оны 06-р сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн ТУЗ-ийн даргаар Ц.Баярбаатарыг томилсугай.

ДАРГА  Ц.БАЯРБААТАР

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 06-р сарын 29-ний өдөр

Дугаар 06/02

Улаанбаатар хот

Нарийн бичгийн даргыг томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани /цаашид "Компани" гэх/-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.53 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/-ийн 2020 оны 06-р сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар М.Баярманла-г томилсугай.

ДАРГА  Ц.БАЯРБААТАР

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 06-р сарын 29-ний өдөр

Дугаар 06/03

Улаанбаатар хот

Хороодын гишүүдийг томилох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2, 81 дүгээр зүйлийн 81.4 дахь хэсэг, Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ хувьцаат компани /цаашид "Компани" гэх/-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.46 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/-ийн 2020 оны 06-р сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Нэг. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшуулалын хороог тогтоолын хавсралт ёсоор баталсугай.

ДАРГА  Ц.БАЯРБААТАР



“ДСЦТС” ХК-ИЙН ТУЗ-ИЙН
2020 ОНЫ 06-Р САРЫН 29-НИЙ
ӨДРИЙН 06/03 ТООТ ТОГТООЛЫН
ХАВСРАЛТ

“ДСЦТС” ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН

Нэг. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай: даргаар: Л.Балган /хараат бус гишүүн/, гишүүдээр: Э.Долгорсүрэн /ердийн гишүүн/, Г.Бэхбат /хараат бус гишүүн/.

Хоёр. Нэр дэвшүүлэх хороог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай: даргаар: Ц.Баярбаатар /хараат бус гишүүн/, гишүүдээр: Г.Бэхбат /хараат бус гишүүн/, Н.Эрдэнэбат /ердийн гишүүн/.

Гурав. Цалин урамшуулалын хороог дараах бүрэлдэхүүнтэй томилсугай: даргаар: Ц.Хангай, /ердийн гишүүн/, гишүүдээр: Г.Бэхбат /хараат бус гишүүн/, Л.Балган /хараат бус гишүүн/.

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 6-р сарын 29-ний өдөр

Дугаар 06/04

Улаанбаатар хот


Компанийн бизнес төлөвлөгөө, төсвийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.2 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн 2020 оны зорилтод түвшингийн тодотголыг энэхүү тогтоолын Хавсралт 1-ийн дагуу баталсугай.

Хоёр. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (С.Нэргүй), Дэд захирал бөгөөд Ерөнхий Инженер (Б.Батжаргал), Ерөнхий Нягтлан бодогч (М.Гэрэлмаа) нарт даалгасугай.

ДАРГА  Ц.БАЯРБААТАР



ДСЦТС” ХК-ийн ТУЗ-ийн 2020
оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 06/04
тоот тогтоолын Хавсралт 1

**“ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ХУВЬЦААТ
КОМПАНИЙН 2020 ОНЫ ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН ТОДОТГОЛ**

ТУЗ-ийн 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн
ТООТ ТОГТООЛЫН ХАВСРАЛТ №....



**"ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХК-ИЙН 2020 ОНЫ ТЕХНИК,
 ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН ТОДОТГОЛ**

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2019 он гүйцэтгэл	2020 оны зорилт	2020 оны тарифт туссан	2020 оны тодотгосон төлөвлөгөө
1	Худалдаж авсан цахилгаан	сая.кВтц	476.76	480.70	482.70	441.62
2	ЦЭХ-ний түгээлтийн алдагдал: хувиар	хувь	10.11%	11.86%	11.86%	11.58%
	биетээр	сая.кВтц	48.2	57.0	57.2	51.1
3	Борлуулах цахилгаан эрчим хүч	сая.кВтц	428.6	423.7	425.5	390.5
4	Нийт орлого	сая.төг	91487.8	97323.9	95188.9	90170.1
	Борлуулалтын орлого	сая.төг	72236.2	75666.6	75383.4	68459.8
	Түгээх үйлчилгээний орлого	сая.төг	17717.5	21027.3	19175.5	19175.5
	Үйл ажиллагааны бусад орлого	сая.төг	1534.1	630.0	630.0	2534.8
5	Нийт зардал	сая.төг	90834.8	97143.9	95008.9	89777.7
	Үндсэн үйл ажиллагааны зардал	сая.төг	20272.6	23363.7	21306.1	21303.6
	ХАЦЭХ-ний төлбөр	сая.төг	69275.5	73330.2	73252.8	67024.1
	Үйл ажиллагааны бусад зардал	сая.төг	1286.7	450.0	450.0	1450.0
6	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	сая.төг	653.0	180.0	180.0	392.5
	Орлогын албан татвар	сая.төг	71.2	18.0	18.0	39.2
	Цэвэр ашиг /алдагдал/	сая.төг	581.8	162.0	162.0	353.3
7	Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ	сая.төг	7283.4	6268.5	6268.5	5728.8
8	Дундаж үнэ		168.65	149.32	168.65	168.65
9	ХАЦЭХ-ний тариф	төг/кВт.ц	145.30	152.55	151.77	151.77
10	Түгээх үйлчилгээний төлбөр	сая.төг/сар	1476.5	1752.3	1598.0	1598.0

ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХУВЬЦААТ КОМПАНИ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 06-р сарын 29-ний өдөр

Дугаар 06/05

Улаанбаатар хот


Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, 55 дугаар зүйлийн 55.6 дахь хэсэг “Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” хувьцаат компани (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.32.5 дахь хэсэг болон 7.34 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх)-ийн 2020 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Компанийн эд хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, бизнес үнэлгээ хийх байгууллагыг сонгох, холбогдох гэрээ, түүний нэмэлт өөрчлөлтийг хийх, гэрээг дуусгавар болгох, үнэлгээний тайланг хүлээн авах эрх үүргийг Компанийн Ерөнхий захирал С.Нэргүйд олгосугай.

Хоёр. Компанийн эд хөрөнгийн үнэлгээ, бизнес үнэлгээг хийлгэсэн тохиолдолд тэрхүү үнэлгээг тухай бүр ТУЗ-д танилцуулахыг Компанийн Ерөнхий захирал С.Нэргүйд даалгасугай.

ДАРГА



Ц.БАЯРБААТАР